



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/247

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголын хүүхдийн анагаахын нийгэмлэг"-тэй хамтран зохион байгуулах "Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн үзлэг" сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтын удирдамжийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Б.НАРАНТУЯА



Ерөнхий захирлын 2017 оны 12 дүгээр сарын 19 ны
өдрийн А/... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт
1247

“ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ҮЗЛЭГ” –ИЙН СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Үндэслэл

Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг дэмжих хамгаалахад гэр бүл, эцэг эх болон өрхийн эмч, эмнэлгийн мэрэгжилтний хамтын ажиллагаа нэн чухал юм. Олон улсад хүүхдийн тодорхой хөгжлийн насанд үзлэгт хамруулж аливаа эмгэг болон хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэн хөгжлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах үйл ажиллагаа хэвшсэн байна. Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийг цогцоор нь тандаж хянаж, аливаа эмгэг болон хөгжлийн хоцрогдлын эрсдэлтэй хүүхдийг бага насанд нь олж илрүүлэх үйл явц нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага –өрх сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллгаатай холбоотой. Ингэхдээ өрх сумын эрүүл мэндийн ажилтан бүрийг “Хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг” хийх талаар сургалтанд хамруулж, эрүүл мэнд, хөгжлийг үнэлэх арга барилд сургах нь чухал юм.

Хүүхдийн эмч нар хүүхдийн хөгжлийн хоцрогдлын дөнгөж 30 орчим хувийг илрүүлдэг бол хяналтын хуудас, үзлэг нь 70 орчим хувийг илрүүлж чаддаг гэсэн судалгаа байдаг.

Хүүхдийн эмч нар хүүхдийн хөгжлийн хоцрогдлын дөнгөж 30 орчим хувийг илрүүлдэг бол хяналтын хуудас, үзлэг нь 70 орчим хувийг илрүүлж чаддаг байна.

Японы Баянгол дүүрэгт хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” (START)–ийн хүрээнд тус дүүргийн 109 өрхийн эмчийг сургалтанд хамруулж, үзлэг зохион байгуулсан бөгөөд 5-р сард үзлэгт хамрагдсан 18 сартай 377 хүүхдээс хэл ярианы хоцрогдолтой 42 хүүхэд хөдөлгөөний хоцрогдолтой 11 хүүхэд илэрсэн байна.

Эдгээрийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/358 тоот тушаалд 18 сар, 36 сартай хүүхдэд эрүүл мэндийн цогц үзлэг хийж хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг илрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар заасан тул тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн

цогц үзлэгийн маягтыг боловсруулан, үзлэг хийх аргыг зааж сургах сургаг багшийн сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

Зорилго: Аймаг, дүүргүүдийн сум өрхийн эмч нарт хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн скрининг - үзлэг хийх аргыг эзэмшүүлэх сургалт явуулах сургагч багш бэлтгэх

Үйл ажиллагааны чиглэл

1. Сургагч багшийн сургалтанд оролцож, орон нутагтаа хичээл заах багш нарыг сонгох
2. Үзлэгийн маягтыг боловсруулах
3. 2 өдрийн сургалт зохион байгуулж сургагч багш бэлтгэх

Хамрах хүрээ : Нийслэлийн 9 дүүрэг, Төв, Дархан, Хэнтий, Баянхонгор аймгууд

Оролцох хүний тоо: 40 хүн /орон нутгаас 8 хүн/


Хугацаа : 2017 оны 12 дугаар сарын 15-2018 оны 1-р сарын 15

Нийт зардал 5 836 000

Зохион байгуулагч байгууллага : Монголын хүүхдийн анагаахын нийгэмлэг, Эрүүл мэндийн хөгжлийн төв, АШИУС-ын хүүхдийн анагаахын тэнхим

Хүлээгдэж буй үр дүн: Хүүхдийг тодорхой насанд эрүүл мэнд, хөгжлийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хөгжлийн хоцрогдол болон бусад өвчин эмгэгийг илрүүлэх талаар дүүргийн ЭМТ болон орон нутгийн чадавх сайжирч сургалт зохион байгуулах боломж бүрдэнэ. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ бэхжинэ.

Ерөнхий захирлын 2017 оны 12 дүгээр сарын 19 ны
өдрийн 4 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
247.



**“ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, ХӨГЖЛИЙН ҮЗЛЭГ” –ИЙН СУРГАГЧ БАГШ
БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТӨСӨВ**

№	Зардлын утга	Төсөвлөсөн /төг/	
1	Орон нутгаас оролцогчдын байр, хоол, сургалтын өрөө, өдөрт 2 удаа цайны завсарлага, гарын авлага	100 хүн х 25000 төг х 2 өдөр	5 000 000
2	Багшийн ажлын хөлс/Доктор/	$(2*20000*8цаг)*2$ өдөр	640000
3	Багшийн ажлын хөлс/Магистр/	$(2*10000*8цаг)*2$ өдөр	320000
4	Бичиг хэрэг	100 хүн х 3000 төг	300000
5	Гэрчилгээний үнэ	100*1000	100000
6	Баннер	2*35000	70000
7	Заалны түрээс	300000*2өдөр	600000
	БҮГД		7030000